

6-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР

ХУВИЛБАР А

Нэр:

Анги:

Хугацаа: 60 мин

Нийт оноо: 20

Эхийг уншаад, утгыг ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгэнэ үү.

**Эцгийн захиас**

Эрт урьд цагт гурван хүүтэй нэгэн анчин байжээ. Тэрээр ан гөрөө хийж, аж төрөн суудаг байв.

Анчин насан өндөр, хүчин дорой болж, нэг өдөр утаа гартал татаж тавьдаг увдист шар нумаа их хүүдээ өгч, "Миний гурван хүү тулга хийх нэг нэг чулуу олж ир." гэжээ. Гурван хүүгийнхээ авчирсан чулууг тулга болгон, гал түлж, тогоо тавиад, цай чанаж эхэлжээ. Дараа нь "Та гурав тус тусын авч ирсэн чулуугаа ав." гэснийг ёсоор болгохуйд тогоо нь хөмөрч, цай нь асгарч, гал нь унтарчээ.

Тэгсний хойно " За, миний гурван хүү харав уу? Орчлон гэдэг тогооны ёроол адил бөөрөнхий. Иймээс тулгын гурван чулуу шиг бие биеэ харж, эвтэй явах хэрэгтэй. Хэрэв эвдрэлцэж муудвал энэ хөмөрсөн тогоо, асгарсан цай, унтарсан гал мэт болно." хэмээн сургамжилжээ.

1. Тулгын гурван чулуугаар юуг бэлгэдсэн бэ? /2 оноо/  
.....  
.....
2. "Анчин насан өндөр, хүчин дорой болж байна." гэсэн одоо цагийн утгатай өгүүлбэрийг өнгөрсөн цагийн утгатай өгүүлбэр болгон хувиргаж бичнэ үү /2оноо/  
.....  
.....
3. Ойр орчмын үг, өгүүлбэрийн утгаас үгийн утгыг ойлгон хамгийн оновчтой тайлбарласан хэсгийг олж дугуйлаарай. /2оноо/  
дорой –  
а. Үгээгүй дорой    b. Ядуу дорой    c. Сул дорой    d. Үхээнц дорой
4. Нэр язгуур + нэрээс нэр үг бүтээх дагавар + олон тооны дагавар + тийн ялгалын нөхцөл + хамаатуулах нөхцөл бүдүүвчид тохирох үгийг олно уу /2оноо/  
а. Тариаланчдынхаа    b. Малчдынхаа    c. Монголчуудынхаа    d. Сэтгүүлчдийнхээ
5. "чулуу" гэдэг үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгах зөв бичгийн дүрмийг тайлбарлаж бичнэ үү /2оноо/  
.....  
.....
6. Өөрийнхөө хамгийн эрхэм нандин зүйлсийг есөн эрдэнэтэй адилтгаж бичээрэй./5оноо/  
.....  
.....  
.....  
.....

7. Үндэсний бичгээр зөв уншаад кирилл бичигт хөрвүүлэн бичээрэй. /5оноо/



.....  
.....  
.....  
.....  
.....  
.....

6-Р АНГИЙН МОНГОЛ ХЭЛ БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН АНГИ ДЭВШИХ

ШАЛГАЛТЫН ДААЛГАВАР

ХУВИЛБАР Б

Нэр:

Анги:

Хугацаа: 60 мин

Нийт оноо: 20

Эхийг уншаад, утгыг ойлгосны дараа даалгаврыг гүйцэтгэнэ үү.

**Янзагатай согоо**

Согоо хөл дээрээ тэнцэж ядан байгаа янзагаа хөхүүлэн зогсоно. Тэр янзагаа үнэрлэнгээ салхины аясаар эвгүй үнэр ирэхийг мэдэрч, чоно ойрхон ирж явааг гадарлав. Гэлээ ч хөл дээрээ тэнцэн ядан байгаа янзагатай согоо хаашаа ч явах билээ дээ... Чоно согоог барихад бэлэн болжээ. Согоо зугтмаар байвч янзагандаа хоргодоод, хаашаа ч хөдөлсөнгүй. Тэр өвчүүн дороо янзагаа зогсоож, өөрийн амиа золиосонд гаргахад бэлэн зогсоно. Чоно дайрах мөчид согоо янзагаа даран урд хоёр хөл дээрээ сөхрөх үед чоно түүний дээгүүр нь харайж, эрчиндээ уналаа. Тэгснээ босон, эргэж ч харалгүй цааш хурдлав.

8. Согоо чононоос айн зугтахгүй байсны учирьг тайлбарлан бичнэ үү /2 оноо/  
.....  
.....
9. “Чоно согоог барихад бэлэн болно.” гэсэн ирээдүй цагийн утгатай өгүүлбэрийг одоо цагийн утгатай өгүүлбэр болгон хувиргаж бичнэ үү /2оноо/  
.....  
.....
10. Ойр орчмын үг, өгүүлбэрийн утгаас үгийн утгыг ойлгон хамгийн оновчтой тайлбарласан хэсгийг олж дугуйлаарай. /2оноо/  
Сөхрөх -  
а. Сөхөрч суух      б. Сөхөрч унах      с. Сөхөрч мөргөх      d. Сөхөртлөө ажиллах
11. Үйл язгуур + нэрээс нэр үг бүтээх дагавар + олон тооны дагавар + тийн ялгалын нөхцөл + хамаатуулах нөхцөл бүдүүвчид тохирох үгийг олно уу /2оноо/  
а. Тариаланчдынхаа      б. Малчдынхаа      с. Монголчуудынхаа      d. Сэтгүүлчдийнхээ
12. “янзага” гэдэг үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгах зөв бичгийн дүрмийг тайлбарлаж бичнэ үү /2оноо/  
.....  
.....
13. Өөрийнхөө хамгийн эрхэм нандин зүйлсийг есөн эрдэнэтэй адилтгаж бичээрэй./5оноо/  
.....  
.....  
.....
14. Үндэсний бичгээр зөв уншаад кирилл бичигт хөрвүүлэн бичээрэй. /5оноо/

شعر ۴ نغمه‌ها

شعر ۴ نغمه‌ها همیشه و جوان شعر  
شعر ۴ نغمه‌ها همیشه و جوان شعر ..

«مستقیم» شعر ۴ نغمه‌ها

حسین و یونس ۴ نغمه .. شعر ۴ نغمه

شعر «نغمه‌ها» نغمه شعر

و یونس .. و حسین هم «نغمه‌ها»

شعر «نغمه‌ها» شعر ۴ نغمه ..

.....

.....

.....

.....

.....

.....